



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 1/2017

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2.5 дэх заалт, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 35 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн цэнгэлдэх хүрээлэнгийн барилгыг Хот тохижуулах газраас Биеийн тамир, спортын газарт хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Эрдэнэсүрэн – ЗДТГ-ын дарга

Нарийн бичгийн дарга: О.Шинэжаргал - Орон нутгийн өмчийн газрын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: М.Наранбадрах – Биеийн тамир, спортын газрын даргын үүрэг гүйцэтгэгч

Д.Мөнхцоож – Хот тохижуулах газрын дарга

Э.Энхмэнд – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын техник хяналт хариуцсан мэргэжилтэн

Хоёр. Хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу хүлээлцүүлэхийг ажлын хэсэг /Ц.Эрдэнэсүрэн/-т даалгасугай.

Гурав. Барилгыг данс бүртгэлдээ авч ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Биеийн тамир, спортын газар /М.Наранбадрах/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200780